



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 5/02

Ховд

Г.Гончигсүрэнг ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 57 дугаар зүйлийн 57.2.2, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10, Ховд аймгийн төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 39 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 05\10917 тоот албан бичгээр хянагдаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас томилуулах санал дэмжигдсэн Гомбоогийн Гончигсүрэнг 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалд томилсугай.

2 Г.Гончигсүрэнг Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралтын Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-9-ийн 5 дахь шатлал 864211 төгрөг /найман зуун жаран дөрвөн мянга, хоё зуун арван нэгэн/-өөр цалинжуулж, төрийн алба хаасны нэмэгдлийг 20 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 22 хувиар тус тус үндсэн цалингаас сар бодож олгохыг Хүнс,хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч /Ж.Болормаа/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Г.Гончигсүрэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Зах Б/02 Ч
02 00020